



ДУНДГОВЫЙ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 8/30

Онги

Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл олгож  
тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Хувиараа хөдөлмөр эрхлэгч Д.Сүхбаатарын тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл 2 жилийн хугацаагаар сунгасугай.
- Иргэн Ц.Өлзийтүвшин нь Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.14 дахь заалтыг хангаж байгаа тул тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл 2 жилийн хугацаагаар олгосугай.

ЗАСАГ ДАРГА *С.Амарсаная* С.АМАРСАННАА



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 10 сөдөр

Дугаар 1168

Мандалговь

Архи, согтууруулах ундаа худалдах  
түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрх  
олгох, сунгах тухай

Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дүгээр зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй Мөнхдэлгэрэх-Оюу, Цант-Өлзийт, Сэргүүн Онги, Тойн хайрхан, Хос гарыд магнаг, Төгрөгийн итгэлцэл, ХХК-ны хүнсний дэлгүүрүүдийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хугацаагаар тус тус сунгасугай.

Хоёр. Сайнцагаан сумын Жинд болор ХХК-ны Болор плаза худалдааны төв, Өндөршил сумын Шилийн хурд ХХК-ны хүнсний дэлгүүрт архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хугацаагаар олгосугай.

Гурав. Мөнхдэлгэрэх-Оюу, Тойн хайрхан, Хос гарыд магнаг ХХК-ны хүнсний дэлгүүр, Жинд болор ХХК-ны Болор плаза худалдааны төвийн ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 08.00-24.00, Шилийн хурд, Цант-Өлзийт, Сэргүүн Онги, Төгрөгийн итгэлцэл ХХК-ны худалдааны газруудын ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 09.00-21.00 цаг хүртэл хугацаагаар тус тус баталсугай.

Дөрөв. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Татварын хэлтэс (М.Туяацэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), холбогдох сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О. БАТ-ЭРДЭНЭ



482010467

МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 09 өдөр

Дугаар 1/447

Мандалговь

Г Архи, согтууруулах ундаа худалдах түүгээр  
Үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрх  
олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайхан-Овоо сумын "Элбэг онгийн хишиг" ХХК-ийн хүнсний дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр хүртэлх хугацаагаар олгосугай.

2. Сайнцагаан сумын "Мөнх дэлгэрэх оюу", "Ихэр гэр чулуут", "Эгшиглэnt бүрд", "Хишиг цагаан овоо" ХХК, Сайхан-Овоо сумын "Сэргүн онги" ХХК, Өндөршил сумын "Мөнхдүүрэн арвай" ХХК, Гурвансайхан сумын "Буманцагаан хоньт" ХХК-ийн хүнсний дэлгүүрт архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, Сайнцагаан сумын "Жинд болор" ХХК, Өндөршил сумын "Чебу" ХХК-ийн караоке бааранд архи, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр хүртэлх хугацаагаар сунгасугай.

3. Гарсан шийдвэрийг холбогдох газарт хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

4822111388

